



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 -р сарын 13-ны өдөр

№ А/05-Т

Улаанбаатар хот

*Ногдол ашиг хуваарилах тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвесткор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.18 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.16 дахь заалт, болон “Ногдол ашгийн бодлого”-ын 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр гаргасан “Үнэт цаасны танилцуулга” дахь “Санхүүгийн байдлын тайлангийн дунд хугацааны төлөвлөлт”, болон 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын “2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах” тухай хэлэлцүүлэгт дурьдсаны дагуу 2019 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй болохыг тогтоосугай;
2. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д үүрэг болгосугай.





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02 -р сарын 13-ны өдөр

№ А/06-Т

Улаанбаатар хот

*Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5 дах заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалт болон “Инвесткор ББСБ” ХК (“Компани” гэх)-ийн Дүрмийн 9.6.5, 9.6.19 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмын дагуу олон нийтэд нээлттэй арилжаалах зорилгоор нийт 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дун бүхий Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид “**Баталгаат үнэт цаас**” гэх) – ыг 2020 оны эхний хагаст багтаан гаргасугай;
2. Баталгаат үнэт цаас гаргахтай холбогдуулан Компанийн автомашины зээлийн багцаас сонгон тусгаарлаж, “Инвесткор Актив” гэх оноосон нэр бүхий тусгай зориулалтын компани (цаашид “**ТЗК**” гэх) байгуулах ажлыг зохион байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/- д даалгасугай;
3. ТЗК-ийг үүсгэн байгуулах, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах, Баталгаат үнэт цаас бүртгүүлэх болон хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор болон бусад этгээдтэй гэрээ хэлцэл байгуулахтай холбоотой асуудлаар ТЗК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн хувьд “Инвесткор ББСБ” ХК-ийг төлөөлөн шийдвэр гаргах эрхийг ТУЗ-ийн дарга /Б.Анхболд/-д олгосугай;
4. Баталгаат үнэт цаас гаргах, ТЗК-д хөронго шилжүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай судалгаа, шинжилгээг хийлгэхээр хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж ажиллах, ТЗК-д шилжүүлэх зээлийн багцын жагсаалтыг гаргах, хөрөнгө шилжүүлэх гэрээ байгуулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д даалгасугай;
5. ТЗК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авах хүртэлх хугацаанд түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий Гүйцэтгэх захирлаар Д.Баясгаланг томилсугай;
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох шаардлагатай арга хэмжээг авч ажиллан ажлын үр дүнг танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д даалгасугай.





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 02-р сарын 13-ны өдөр

№ А/09-Т

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг  
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 02 дугаар бүлгийн 2.1, 2.3 дахь заалт, 03 дугаар бүлэг болон “Инвесткор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 09-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд зарлан хуралдуулсугай;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
  - 2.1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
  - 2.2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
  - 2.3. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн батлах;
  - 2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсөв батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай;
4. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;
5. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Компани болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр нийтэд мэдээллэж, зарын давталтыг 2020 оны 03 дугаар сарын 04-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээллэсүгэй;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хоёрдугаар хавсралтаар баталж, баримт бичгийг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчид үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим

хэлбэрээр хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/-д үүрэг болгосугай;

7. “Хурлын санал авах хуудас”-ын загварыг энэхүү тогтоолын Гуравдугаар хавсралтаар баталсугай;
8. Компанийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/, болон Хурал зохион байгуулах комисс /Р. Мөнхтөр/-д даалгасугай;
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “Инвесткор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-г томилсугай;
10. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - 10.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:  
Р. Мөнхтөр                   Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн Дэд захирал
  - 10.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

А. Энэрэл	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга
З. Балжиржанцан	Санхүүгийн шинжээч
Г. Гантуяа	Салбар хариуцсан менежер
Б. Болормаа	Хуулийн зөвлөх
Б. Хөлгэн	Бизнес хөгжлийн мэргэжилтэн
Э. Нинжбадгар	Хүний нөөцийн менежер
Б. Мөнхсүлд	Мэдээлэл технологи хариуцсан менежер
Б. Мөнх-Эрдэнэ	Оффис менежер
11. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
  - 11.1. Тооллогын комиссын дарга:  
А. Баттүвшин                 “Инвесткор капитал УЦК” ХХК
  - 11.2. Тооллогын комиссын гишүүд:  
Ж. Азбаяр                     “Инвесткор капитал УЦК” ХХК  
Г. Лхагва-Очир                 Салбар хариуцсан нягтлан бодогч
12. Хувьцаа эзэмшигчдийн “Хурлын санал авах хуудас”-ыг үнэт цаасны брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт хүлээн авах эцсийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 18:00 цагт тасалбар болгохоор тогтоосугай;
13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /А. Энэрэл/, Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/-д тус тус үүрэг болгосугай.





Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02-р сарын 13-ны өдрийн  
хуралын А/09-Т тоотын Нэгдүгээр хавсралт

**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР**

<b>Компанийн нэр:</b>	Инвекор ББСБ ХК
<b>Хурлын төрөл:</b>	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
<b>Хурал хуралдах өдөр, цаг:</b>	2020 оны 04 дүгээр сарын 09, 14:00 цагт
<b>Хурал хуралдах газар:</b>	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туусин зочид буудлын Соёмбо хурлын танхим
<b>Бүртгэлийн өдөр:</b>	2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр
<b>Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:</b>	<ol style="list-style-type: none"> <li>Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;</li> <li>Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;</li> <li>Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн батлах;</li> <li>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсөв батлах</li> </ol>
<b>Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:</b>	<p>Хувьцаа эзэмшигчид нь 2020 оны 02 дугаар сарын 24-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилиерийн компани болон Компанийн төв байранд ирж хурлын баримт бичигтэй танилцааж болно.</p> <p>Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:30-18:30 цагийн хооронд ажиллана.</p>
<b>Хурал хуралдах шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:</b>	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/09-Т тоот тогтоол.
<b>Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:</b>	<p><b>Хурлын комиссын дарга:</b> Эс Ай Би Жэй Капитал ХХК-ийн Дэд захирал, Р. Мөнхтөр, <a href="mailto:munkhtur@invescore.mn">munkhtur@invescore.mn</a>, 99082981</p> <p><b>Хурлын комиссын гишүүд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга А. Энэрэл, <a href="mailto:enerel@invescore.mn">enerel@invescore.mn</a>, 88103947</li> <li>Санхүүгийн шинжээч З. Балжиржанцан, <a href="mailto:baljirjantsan@invescore.mn">baljirjantsan@invescore.mn</a>, 90049978</li> <li>Салбар хариуцсан менежер Г. Гантуяа, <a href="mailto:gantuya@invescore.mn">gantuya@invescore.mn</a>,</li> <li>Хуулийн зөвлөх Б. Болормаа, <a href="mailto:bolormaa@invescore.mn">bolormaa@invescore.mn</a>, 86109494</li> <li>Бизнес хөгжлийн мэргэжилтэн Б. Хөлгэн, <a href="mailto:khulgen@invescore.mn">khulgen@invescore.mn</a>, 99082061</li> <li>Хүний нөөцийн менежер Э. Нинжбадгар, <a href="mailto:Ninjbadgar@invescore.mn">Ninjbadgar@invescore.mn</a>, 91110650</li> <li>Мэдээлэл технологи хариуцсан менежер Б. Мөнхсүлд, <a href="mailto:munkhsuld@invescore.mn">munkhsuld@invescore.mn</a>, 99992632</li> <li>Оффис менежер Б. Мөнх-Эрдэнэ, <a href="mailto:munkherdene.b@invescore.mn">munkherdene.b@invescore.mn</a>, 90049933</li> </ol>

\*\*\*\*\*

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦХАС СУДАЛТАЙ  
ХОЛБООТОЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн жагсаалт
1	“Инвекор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/09-Т тоот тогтоол;
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4	Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
5	“Инвекор ББСБ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан;
6	“Инвекор ББСБ” ХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэл;
7	“Инвекор ББСБ” ХК-ийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/08-Т тоот тогтоол;
8	“Инвекор ББСБ” ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл;
9	“Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийн санал;
10	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл;

\*\*\*\*\*



**“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**  
Хэлэлцэх асуудал № 1,2,3

Хувьцаа эзэмшигчийн:

Овог: \_\_\_\_\_ Нэр : \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр \_\_\_\_\_

Бүртгэсэн Брокерийн овог, нэр \_\_\_\_\_

Энэхүү Санал авах хуудсаар 2020 оны 04-р сарын 09-ны өдрийн 14:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын Соёмбо хурлын танхимд хуралдах Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзэн
1.	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТҮЗ-ийн дүгнэлтийг батлах;			
2.	Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах саналыг хэлэлцэн батлах;			
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны төсвийг батлах			
4.	Бусад			

**Санал авах хуудсыг ашиглах санамж:**

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт  тэмдгийг бичнэ үү.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал тэмдэглэн, үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниад 2020 оны 04 дүгээр сарын 08-ны 18:00 цагаас өмнө хүргүүлнэ.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
- Засварласан, балласан, залруулгатай, болон нэгээс олон санал өгсөн санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

Брокерийн гарын үсэг \_\_\_\_\_ /гарын үсэг/  
/тамга/

2020 оны \_\_\_\_-р сарын \_\_\_\_-ны өдөр

